



Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн
147 дугаар тушаалын хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ТОГТООХ, ТЭДГЭЭРТ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн этгээдэд мөн хуулийн 4.1.21-д заасан зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) олгох, бүртгэх, хугацааг сунгах, нэмэлт ажлын төрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, мэдээлэлд өөрчлөлт оруулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.2. Тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, хяналт тавих үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Барилгын тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ журмаар зохицуулна.
- 1.3. Энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан суурь нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоно.
- 1.4. Барилгын тухай хуулийн 20.2-т заасан барилга байгууламжийн зураг төсөл болон барилгын ажилд тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжид олгоно.
- 1.5. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх эрхлэх тусгай зөвшөөрлийг Барилгын тухай хуулийн 33.1.15-д заасны дагуу барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож, хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.
- 1.6. Хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлыг Барилгын тухай хуулийн 34.1.14-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа байгууллага /цаашид “зохион байгуулагч байгууллага” гэх/ нэг цэгийн үйлчилгээ болон цахим системээр зохион байгуулна.
- 1.7. Барилга байгууламжийн буулгалтын ажлыг тухайн барилгын ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд гүйцэтгэнэ.
- 1.8. Зохион байгуулагч байгууллага нь тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9.1-д зааснаас гадна дор дурдсан зарчмыг баримтална. Үүнд:
 - 1.8.1. тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байх;
 - 1.8.2. тусгай зөвшөөрлийг барилга байгууламжийн төвөгшилтэй уялдуулан шатлан ахиулж олгох;
 - 1.8.3. хариуцлага, туршлага, тогтвортой байдалд тулгуурлах.

Хоёр. Зохион байгуулагч байгууллагын чиг үүрэг

- 2.1. Зохион байгуулагч байгууллага тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын албатай байна. Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах;
 - 2.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагатай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх;
 - 2.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагатай байгуулсан гэрээний биелэлтийг хэлэлцүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутам танилцуулах;
 - 2.1.4. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох;
 - 2.1.5. тусгай зөвшөөрлийн хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэлд өөрчлөлт оруулах;
 - 2.1.6. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлаар санал боловсруулах;
 - 2.1.7. энэ журмын 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах.

Гурав. Өргөдлийн хүсэлт гаргах

- 3.1. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтээ зохион байгуулагч байгууллагад Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн цахим систем (цаашид “тусгай зөвшөөрлийн цахим систем” гэх) www.license.mcis.gov.mn -ээр дамжуулан гаргана.
- 3.2. Хүсэлт гаргагч нь “ДАН” танилт нэвтрэлтийн нэгдсэн систем /цаашид “ДАН систем” гэх/-ийг ашиглан иргэний баталгаажуулалт хийсэний дараа төрийн мэдээлэл солилцооны ХУР систем /цаашид “ХУР систем” гэх/-ээр дамжин хуулийн этгээдийн бүртгэлийг үүсгэнэ. Хуулийн этгээд нь зөвхөн нэг бүртгэлтэй байна.

3.3. Хуулийн этгээдийн удирдах болон инженер техникийн ажилтнууд энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу ХУР системээр дамжуулан дараах мэдээллийг баталгаажуулна. Үүнд:

3.3.1. хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл;

3.3.2. иргэний үнэмлэхний мэдээлэл;

3.3.3. нийгмийн даатгалын мэдээлэл;

3.3.4. дээд боловсролын мэдээлэл.

3.4. Барилгын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цахим системийн сургалтын мэдээллийн сангаас мэргэшсэн болон зөвлөх инженерийн мэдээллийг татаж цахим системд оруулна.

3.5. Хуулийн этгээд нь дараах мэдээллийг нэмж оруулна. Үүнд:

3.5.1. холбоо барих мэдээлэл;

3.5.2. систем хариуцсан ажилтны мэдээлэл;

3.5.3. Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй танилцуулга;

3.5.4. Гүйцэтгэсэн ажлын мэдээлэл;

3.5.5. Машин механизм, тоног төхөөрөмжийн мэдээлэл.

3.6. Хуулийн этгээд нь энэ журмын 6-р бүлэгт заасан холбогдох шаардлагыг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрлийн хүсэлтийг үүсгэж илгээнэ.

Дөрөв. Өргөдлийн хүсэлтийг хянаж, баталгаажуулах

4.1. Хуулийн этгээдээс илгээсэн хүсэлтийг зохион байгуулагч байгууллага хүлээн авч материалын иж бүрдэл болон суурь нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж, баталгаажуулна.

4.2. Хуулийн этгээд тусгай зөвшөөрлийг шинээр авах хүсэлт гаргасан тохиолдолд инженер техникийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 1 сар, сунгах болон нэмэлтээр авах хүсэлт гаргасан тохиолдолд сүүлийн 3 сар тасралтгүй төлсөн байна.

4.3. Суурь нөхцөл, шаардлагад заасан мэргэшлийн зөвлөх зэрэгтэй инженер нь тусгай зөвшөөрөлтэй 3 хүртэлх хуулийн этгээдэд ажиллаж болох ба гэрээг мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

4.4. Тусгай зөвшөөрөл сунгах хүсэлтийг тухайн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 хоногоос багагүй хугацаанд гаргана.

Тав. Өргөдлийн хүсэлтийг шийдвэрлэх

5.1. Зохион байгуулагч байгууллага нь хуулийн этгээдийн хүсэлтийг тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авснаас хойш 5 өдрийн дотор (7 хоног бүрийн Пүрэв гарагийн 15.00 цагаар тасалбар болгон) нэгтгэж, баталгаажуулан барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад илгээнэ.

5.2. Энэ журмын 5.1-д заасан баталгаажуулалтыг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох шийдвэрийг ажлын 5 хоногийн дотор гаргана.

5.3. Цахим программ тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол энэ тухай үндэслэлийг тодорхой зааж өргөдөл гаргагчийн цахим системд нь мэдэгдэл илгээнэ.

5.4. Шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээдийн бүрдүүлсэн баримт бичиг болон бусад мэдээллийн өргөдөл шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно.

5.5. БМҮТЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулагч байгууллага нь хуулийн этгээдийн мэдээллийн үнэн зөв байдлыг урьдчилан танилцаж, ажлын албанд танилцуулна. /Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаанд хамаарна/

Зургаа. Цахим системд оруулах мэдээлэлд тавих шаардлага болон бүрдүүлэх баримт бичиг

6.1. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл /БҮАТЗ/ авах хуулийн этгээд нь мэдээллийн сангийн цахим системд бүртгүүлэн зохих журмын дагуу хүсэлтээ шийдвэрлүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.1.1. БҮАТЗ сунгах болон барилгын үйл ажиллагаагаа өргөтгөж, нэмэлт ажлын төрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан хувь хэмжээгээр норм, нормативын санд төлөх шимтгэлийн дүнг оруулах, шимтгэл төлсөн баримтыг хавсаргах

6.1.2. БҮАТЗ олгогчтой байгуулсан гэрээ дүгнэсэн тэмдэглэл;

6.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл сунгах, нэмэлт ажлын төрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ журмын 6.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.2.1. магадлал хийлгэсэн зураг төслийн ажлын мэдээллийг зураг төсөл, магадлалын системээс баталгаажуулна /бүтээлийн нэр, огноо, магадлалын ерөнхий дүгнэлтийн дугаар/.

6.3. Барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл /БМҮТЗ/ авах хуулийн этгээд нь зохион байгуулагч байгууллагын нэг цэгийн үйлчилгээ болон мэдээллийн сангийн цахим системд бүртгүүлэн зохих журмын дагуу хүсэлтээ шийдвэрлүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна Үүнд:

6.3.1. БМҮТЗ сунгах, нэмэлт ажлын төрөл болон шинээр авах хүсэлт гаргасан хуулийн этгээдийн бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ;

6.3.2. Бүтээгдэхүүнд хийлгэсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг;

6.3.3. БМҮТЗ шинээр авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь өөрийн өмчлөлд байгаа зориулалтын технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, анхан шатны лабораторийн багаж хэрэгсэл машин механизмын жагсаалт;

6.3.4. Үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнийхээ чанарын үндсэн үзүүлэлтийг тодорхойлох лабораторитой байх;

- 6.3.5. БМҮТЗ сунгах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа өргөтгөх, хүчин чадал болон бүтээгдэхүүний нэр төрөлд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор нэмэлт ажлын төрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь хийсэн ажлын тайлан, БМҮТЗ олгогчтой байгуулсан гэрээ дүгнэсэн тэмдэглэл.
- 6.4. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тухайлсан объектын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна Үүнд:
- 6.4.1. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зурагт хийсэн магадлалын ерөнхий дүгнэлт, өндөр барилгын мэргэжлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл;
- 6.4.2. Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байх;
- 6.5. Онцгой төвөгшилтэй болон Барилгын тухай хуулийн 20.2-д заасан барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авах, сунгах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ журмын 4.1.-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 6.5.1. Онцгой төвөгшилтэй барилгын ажлыг хийж гүйцэтгэхэд тухайн төслийн зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлтийн тухай мэдээлэл /Огноо, дугаар/;
- 6.5.2. Өндөр төвөгшилтэй барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх;
- 6.5.3. Барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл болон барилгын үйлдвэрлэл, зохион байгуулалт, технологийн мэргэжлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл.
- 6.6. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тухайлсан объектын тусгай зөвшөөрөл нь зөвхөн тухайн объектод хамаарах бөгөөд уг объектыг баригдаж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 6.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гээсэн, үрэгдүүлсэн шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол дор дурдсан баримт бичгийг үндэслэн олгоно. Үүнд:
- 6.7.1. албан хүсэлт;
- 6.7.2. гэрчилгээг гээсэн тухай өдөр тутмын сонинд зарлуулсан хуулбар;
- 6.7.3. Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан хувь хэмжээгээр норм, нормативын санд шимтгэл төлсөн баримт.
- 6.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийн этгээдийн оноосон нэр, эзэмшигчийн нэр өөрчлөгдсөн шалтгаанаар тусгай зөвшөөрлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан бол дор дурдсан баримт бичгийг үндэслэн олгоно. Үүнд:
- 6.8.1. Улсын бүртгэлийн газрын лавлагаа;
- 6.8.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 6.8.3. хуулийн этгээдийн дүрмийн хуулбар;
- 6.8.4. эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эх хувь.
- 6.9. Гадаадын хуулийн этгээд нь БҮАТЗ авах хүсэлт гаргахдаа энэ журмын 6.1-6.6-д заасан хамаарах баримт бичиг бүрдүүлэхээс гадна тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон БҮАТЗ-ийн гэрчилгээний хуулбар, баталгаат орчуулгын эх хувийг хавсаргана. Мөн Барилгын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-д заасны дагуу барилгын үйл ажиллагааг Монгол Улсын хуулийн этгээдтэй хамтран гэрээ байгуулж, эрхэлнэ.
- 6.10. Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь Барилгын тухай хуулийн 34.1.14-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээгээр үйлдлүүлэх үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хэмжээгээр төлнө.
- 6.11. Энэ журмын 6.10-д заасан үйлчилгээний хөлсний хэмжээг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу тогтоох бөгөөд нэг цэгийн үйлчилгээгээр үйлчилгээ авснаас хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.
- 6.12. Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан хуулийн этгээдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь мэргэжлийн инженер, техникийн ажилтан байна. Мөн хос мэргэжилтэй инженер техникийн ажилтан нь тухайн хуулийн этгээдэд өөрийн эзэмшсэн хос мэргэжил тус бүрээр бүртгэгдэх боломжтой байна.

Долоо. Хуулийн этгээдэд тавигдах шаардлага

- 7.1. БҮАТЗ эрхлэх хүсэлт гаргасан /барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх/ хуулийн этгээдэд Барилгын тухай хуулийн 10.1-д заасан ангиллын дагуу барилга байгууламжийн төвөгшлөөр, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдэд үйлдвэрлэлийн төрлөөр, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдэд өргөх байгууламжийн төрлөөр энэ журмын 1 дүгээр хавсралтад зааснаар тогтооно.
- 7.2. Мэдээллийн санд бүртгэлтэй инженер, техникийн ажилтан нь мэдээллийн санд баталгаажсанаас хойш 90 хоногийн дотор шилжилт, хөдөлгөөн хийхгүй бөгөөд шилжилт, хөдөлгөөн хийсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь суурь нөхцөл шаардлагад заасан инженер, техникийн ажилтныг 30 хоногийн дотор нөхөж бүртгүүлнэ.
- 7.3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт гаргасан хуулийн этгээдэд бага төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл олгоно.
- 7.4. Дунд төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд нь бага төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй 1-ээс доошгүй жил үйл ажиллагаа явуулж, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнасан байна.
- 7.5. Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд нь дунд төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөлтэйгөөр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнасан байна.
- 7.6. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд нь өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байна.

Найм. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

- 8.1. Тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу 5 хүртэл жилээр олгож, мөн хугацаагаар сунгах, нэмэлт ажлын төрлийг тухайн тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаагаар олгоно.

8.2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь энэ журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан гэрчилгээний загвараар үнэт цаасан дээр хэвлэгдэх бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4.1-д заасан мэдээлэл болон бусад мэдээллийг тусгана.

8.3. Тусгай зөвшөөрөлтэй эсэх талаарх лавлагааг төрийн үйлчилгээний цахим системээс QR кодоор баталгаажсан нууцлалтай авч болно.

8.4. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн энэ журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй байгуулах гэрээний загварын дагуу зохион байгуулагч байгууллага гэрээг байгуулж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгох, хяналт тавих үйл ажиллагааг шуурхай зохион байгуулна.

Ес. Хэрэгжилтийн явцад хяналт тавих, хариуцлага

9.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно. Мөн Барилгын тухай хуулийн 20.8-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, дүгнэлт гаргуулах асуудлаар барилгын улсын хяналт хэрэгжүүлэх байгууллага болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж, шийдвэрлүүлнэ.

9.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болсноос хойш ажлын 3 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон харьяалах татварын алба, нийгмийн даатгалын байгууллагад албан бичгээр болон цахимаар мэдэгдэнэ.

9.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь барилгын салбарын статистик мэдээ, үйл ажиллагааны тайлангаа 1 жилээс дээш хугацаанд мэдээллийн санд ирүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээ авах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

9.4. Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан хуулийн этгээд нь шийдвэр гарснаас хойш 1 жилийн дотор тусгай зөвшөөрөл эзэмших гэрээ байгуулаагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэлх арга хэмжээг авна.

9.5. Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, бусдын бичиг баримтыг зөвшөөрөлгүйгээр ашигласан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох хүсэлтээс татгалзаж хар жагсаалтад оруулж нийгэд мэдээлнэ.

9.6. Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

9.7. Энэ журмын 9.6-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож тухайн байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлнэ.

Арав. Баримт бичгийг баяжуулах, хадгалах

10.1. Зохион байгуулагч байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн талаарх мэдээллийг шинэчлэх, баяжуулах, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, байгууллага, иргэдийг мэдээллээр ил тод хангаж ажиллана.

10.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх, тайлан мэдээ гаргах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хийж тэдгээрийн үр дүнг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулагч байгууллага хариуцна.

10.3. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн инженер, техникийн ажилтны шилжилт хөдөлгөөнийг Барилгын тухай хуулийн 34.1.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн инженер, техникийн ажилтны шилжилт хөдөлгөөнийг барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй байгууллагууд тус тус гүйцэтгэнэ.

10.4. Долоо хоног бүрийн ажлын албаны баталгаажуулсан тэмдэглэлийг тусгай зөвшөөрлийн тушаал бүрийн эх хувьд хавсаргаж барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим архивд хадгална.

Арван нэг. Бусад

11.1. Тусгай зөвшөөрлийг олгохтой холбогдон иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 17.1-д заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлнэ.

----- оОо -----

“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралт

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
АЖЛЫН ТӨРӨЛ, СУУРЬ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Улаанбаатар хот

2021 он

НЭГ. ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
Суурь нөхцөл, шаардлага:		
1. Барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламжийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туриллага
ЗТ-1.1 Зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламжийн зураг төсөл	Шаардахгүй	Шаардахгүй
2. Бага төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туриллага
ЗТ-2.1 Архитектур, барилга бүтээцийн зураг төсөл[1]	Архитектор-1 Барилгын инженер-2	Барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн инженер нь 3-с доошгүй ажилласан байх
ЗТ-2.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл[2]	Усны барилга байгууламжийн инженер болон усны нөөцийн инженер-2	ИТА-ын аль нэг нь усны барилга байгууламжийн зураг төслийн чиглэлээр 3-с доошгүй жилийн туршлагатай байх
3. Дунд төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туриллага
ЗТ-3.1. Дунд төвөгшилтэй төрөл бүрийн зориулалттай барилгын архитектур, барилга бүтээцийн зураг төсөл[3]	Архитектор-2 Барилгын инженер-2	Архитекторын аль нэг нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй, Барилгын инженерийн аль нэг барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй.
ЗТ-3.2. Усны барилга байгууламжийн зураг төсөл[4]	Усны барилга байгууламжийн инженер-2 Усны нөөцийн инженер эсхүл ус хангамж ариутгах татуургын инженер – 1	Усны барилга байгууламжийн аль нэг инженер нь усны барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх

ЗТ-3.3. Хөнгөн ба хүнд үйлдвэрийн болон агуулахын барилга	Барилгын инженер-1 Тухайн чиглэлийн технологи инженер-2	Барилгын инженер нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх. Тухайн чиглэлийн технологи инженерийн аль нэг нь тухайн чиглэлээр мэргэшсэн зэрэгтэй байх.
байгууламжийн технологийн зураг төсөл		
ЗТ-3.4. Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг	Ус хангамж, ариутгах татуургын инженер-2	Ус хангамж, ариутгах татуургын инженерийн аль нэг нь ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх
ЗТ-3.5. Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг	Дулааны инженер-2	Дулааны инженерийн аль нэг нь дулаан хангамж, агаар сэлгэлтийн системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх
ЗТ-3.6 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламжийн орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээц, технологийн ажлын зураг төсөл	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламжийн зургийн инженер-1; Архитектор-1; Иргэн ба үйлдвэрийн барилгын инженер-1;	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламжийн зургийн инженер нь мэргэшсэн зэрэгтэй байх Архитектор болон барилгын инженер нь зураг төслийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх
ЗТ-3.7. Уул-уурхайн технологийн зураг төсөл, ГЭЗҮ	Эдийн засагч /Уул уурхайн менежмент/-1 Уул уурхайн ашиглалтын технологи инженер-2	Уул уурхайн ашиглалтын технологи инженерийн нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх
4. Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршлага
ЗТ-4.1 Өндөр төвөгшилтэй бүх төрлийн барилга байгууламжийн архитектур, барилга бүтээцийн зураг төсөл[5]	Архитектор-2 Барилгын инженер-2	Архитекторын нэг нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй байх. Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-4.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл[6]	Усны барилга байгууламжийн инженер-2 Усны нөөцийн инженер эсхүл ус хангамж ариутгах татуургын инженер – 1	Усны барилга байгууламжийн инженерийн нэг нь усны барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь усны барилга байгууламжийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх.
ЗТ-4.3 Хөнгөн ба хүнд үйлдвэрийн барилга байгууламжийн технологийн зураг төсөл	Барилгын инженер–2 Тухайн чиглэлийн технологи инженер-2	Барилга байгууламжийн инженерийн 2 нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх. Тухайн чиглэлийн технологи инженерийн аль нэг нь тухайн чиглэлээр мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь тухайн чиглэлээр зөвлөх зэрэгтэй байх.
ЗТ-4.4 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй	Ус хангамж, ариутгах татуургын инженер-3	Ус хангамж, ариутгах татуургын инженерийн аль нэг нь ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй

холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг		байх, нөгөө нь ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх.
ЗТ-4.5. Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг	Дулааны инженер-3	Дулааны инженерийн аль нэг нь дулаан хангамж, агаар сэлгэлтийн системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх нөгөө нь дулаан хангамж, агаар сэлгэлтийн системийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-4.6 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламжийн орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээц, технологийн ажлын зураг төсөл	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламжийн технологийн инженер-2 Газрын тосны хадгалалт тээвэрлэлтийн инженер-1; Архитектор-1; Барилгын инженер-1	Газрын тосны барилга байгууламжийн инженерийн аль нэг нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх. Барилгын инженер, архитектор нь 5 жилээс доошгүй ажилласан байх.
ЗТ-4.7 Уул-уурхайн технологийн зураг төсөл, ГЭЗҮ	Эдийн засагч /Уул уурхайн менежмент/-1 Уул уурхайн ашиглалтын технологи инженер-2	Уул уурхайн ашиглалтын технологи инженерийн нэг нь мэргэшсэн нөгөө нь зөвлөх инженер байх
ЗТ-4.8 Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалтын зураг төсөл	Архитектор-2 Барилгын инженер-1 Тухайн чиглэлийн судлаач-1	Архитекторын аль нэг нь зөвлөх зэрэгтэй байх. Барилгын инженер нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх.
ЗТ-4.9. Газар доорхи гарц тусгай зориулалтын, бусад барилга байгууламжийн зураг төсөл	Архитектор-1 Барилгын инженер-2	Архитектор нь мэргэшсэн зэрэгтэй байх Барилгын инженерийн аль нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх
ЗТ-4.10. Мэдээлэл, холбоо-дохиоллын дамжуулах (магистраль) болон салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн ажлын зураг	Мэдээлэл, харилцаа холбооны инженер-4 Мэдээлэл холбооны технологи инженер-1	Мэдээлэл, холбооны инженерийн аль нэг нь барилга байгууламжийн мэдээлэл, холбоо-дохиоллын системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилга байгууламжийн Мэдээлэл, холбоо-дохиоллын системийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх.
5. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршлага
ЗТ-5.1. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн архитектур, барилга бүтээц, инженерийн хангамж, технологийн зураг төсөл [7]	Архитектор – 2 Барилгын инженер - 3 УХАТ-ын инженер - 2 ДХАС-ийн инженер - 2 Технологи инженер - 1 Цахилгааны инженер-2 Холбооны инженер-2 Автоматжуулалтын инженер-1	Архитекторын нэг нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй байх. Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй, нөгөө нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх. Инженерийн хангамжийн зураг төслийн инженерүүдийн аль нэг нь тухайн чиглэлээр мэргэшсэн зэрэгтэй байх
ЗТ-5.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл [8]	Усны барилга байгууламжийн инженер-3 Усны нөөцийн болон усан цахилгаан станцын инженер-2 УХАТ-н инженер-1	Усны барилга байгууламжийн инженерийн аль нэг нь усны барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь усны барилга байгууламжийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх.
ЗТ-5.3 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламжийн орчны ерөнхий	Газрын тосны барилга байгууламжийн инженер-3 Газрын тосны хадгалалт тээвэрлэлтийн инженер-1	Газрын тосны барилга байгууламжийн инженерийн аль нэг нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх,

төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээц, технологийн ажлын зураг төсөл	Архитектор-1 Барилгын инженер-2 Цахилгааны инженер-1 Цахилгаан системийн автоматжуулалтын инженер-1	нөгөө нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх. Архитектор нь барилгын эзлэхүүн төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй байх Барилгын инженерийн нэг нь барилгын бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх Автоматжуулалтын инженер нь барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх.
ЗТ-5.4 Газрын гүн дэх тусгай зориулалтын болон бусад барилга байгууламжийн зураг төсөл	Архитектор-2 Барилгын инженер-2 Тухайн чиглэлийн технологи инженер-2 Геодези-1	Архитекторын аль нэг нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй байх. Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-5.5. Уул-уурхайн технологийн зураг төсөл, ГЭЗҮ	-Эдийн засагч /Уул уурхайн менежмент/-1 -Уул уурхайн ашиглалтын технологи инженер-3 -Ашигт малтмалын баяжуулалтын технологи инженер-1	Уул уурхайн ашиглалтын технологи инженерийн нэг нь мэргэшсэн нөгөө нь зөвлөх инженер байх
6. Бага, дунд, Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн дотор, гадна инженерийн салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршилага
ЗТ-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл	Ус хангамж, ариутгах татуургын инженер-1	Ус хангамж, ариутгах татуургын инженер нь 5-с доошгүй ажилласан жилийн туршлагатай байх
ЗТ-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивч, хөргөлтийн систем, гадна дулааны салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл	Халаалт агаар сэлгэлтийн инженер-1	Халаалт агаар сэлгэлтийн инженер нь нь 5-с доошгүй ажилласан жилийн туршлагатай байх
ЗТ-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, 35кВ хүртэлх гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл автоматикийн зураг төсөл	Цахилгааны инженер-2	Цахилгааны аль нэг инженер нь барилга байгууламжийн цахилгаан хангамжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх.
ЗТ-6.4 Барилга байгууламжийн дотор мэдээлэл холбоо, галын болон бусад дохиоллын системийн зураг төсөл, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, гадна салбар	Мэдээлэл, холбоо дохиоллын инженер-1	Мэдээлэл, холбоо дохиоллын инженер нь 5-с доошгүй ажилласан жилийн туршлагатай байх

шугам сүлжээний зураг төсөл		
7. Гадна инженерийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршилага
ЗТ-7.1 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн зураг төсөл	Ус хангамж, ариутгах татуургын инженер-2 Усны барилга байгууламжийн инженер-1	Ус хангамж, ариутгах татуургын инженерийн аль нэг нь ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх. Усны барилга байгууламжийн инженер нь мэргэшсэн зэрэгтэй байх
ЗТ-7.2 Дулааны бие даасан 5.0 МВт хүртэлх эх үүсвэрийн барилга байгууламжийн технологи, шугам сүлжээний зураг төсөл	Дулааны инженер-3	Дулааны инженерийн нэг нь дулаан хангамжийн зураг төслийн мэргэшсэн, нөгөө нь дулаан хангамжийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх.
ЗТ-7.3 Бага хүчин чадлын цахилгааны эх үүсвэр, (бие даасан болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр) түүнтэй холбогдох шугам сүлжээ, барилга, байгууламжийн технологийн зураг төсөл	Цахилгааны инженер-3	Цахилгааны инженерийн нэг нь цахилгаан хангамжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь цахилгаан хангамжийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх.
ЗТ-7.4 Мэдээлэл, харилцаа холбоо дохиоллын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн зураг төсөл	Мэдээлэл, холбоо-дохиоллын инженер-2	Мэдээлэл, холбоо-дохиоллын инженерийн нэг нь барилга байгууламжийн мэдээлэл, холбоо-дохиоллын зураг төслийн мэргэшсэн, нөгөө нь барилга байгууламжийн мэдээлэл, холбоо-дохиоллын зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх.
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршилага
ЗТ-8.1 Барилга угсралтын ажлын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)	Барилгын инженер-1	Барилгын инженер нь 3-с доошгүй жил ажилласан туршлагатай байх
9. Инженер геологийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршилага
ЗТ-9.1 А. Инженер геологийн дунд, том масштабын зураглал, инженер-геологийн зориулалттай (инженер-гидрогеологи, инженер-геокриологи, инженер геозкологи гэх мэт) суурь судалгаа Б. Багаас онцгой төвөгшилтэй бүх төрлийн барилга байгууламжийн инженер-геологийн судалгаа (инженер-геологийн нөхцөл харгалзахгүй)	Инженер-геологийн зөвлөх инженер-1 Талбайн геотехникийн туршилтын мэргэшсэн инженер-1 Лабораторийн инженер геологич / геотехник/ туршилтын мэргэшсэн инженер-1 Инженер-геологийн /геотехник/ бакалавр инженер -2	Аль нэг нь инженер-геологийн судалгааны зөвлөх инженерийн зэрэгтэй, нэг нь талбайн инженер геологич /геотехник/ туршилтын, нэг нь лабораторийн инженер геологич / геотехник/ туршилтын мэргэшсэн зэрэгтэй байна.
ЗТ-9.2 А. Багаас дунд төвөгшилтэй бүх төрлийн барилга байгууламжид зориулсан инженер-геологийн судалгаа (инженер-геологийн нөхцөл харгалзахгүй) Б. Өндөр болон онцгой төвөгшилтэй барилга байгууламжид зориулсан судалгааг инженер-	Инженер-геологийн зөвлөх инженер-1 Инженер-геологийн /геотехник/ мэргэшсэн инженер -1 Инженер-геологич -1 /геотехник/	Аль нэг нь инженер-геологийн / геотехник/ судалгааны зөвлөх зэрэгтэй, нэг нь мэргэшсэн зэрэгтэй байна.

геологийн энгийнээс дунд зэргийн нөхцөлтэй байршилд		
*-Инженер-геологич” мэргэжилд инженер-геологич, гидрогеологич, гео-экологич мэргэжлийн инженерүүд нэгэн адил хамрагдана.		
10. Барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, төсөв		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршилага
ЗТ-10.1 ТЭЗҮ /тухайн ажлын төрлийн хүрээнд/	Эдийн засагч, санхүүгийн болон менежментийн чиглэлийн мэргэжилтэн-2 Тухайн чиглэлийн инженер-2	Эдийн засагчийн аль нэг нь мэргэшлийн зэрэгтэй нөгөө нь ТЭЗҮ боловсруулж байсан ажлын туршлагатай байх. Мэргэжлийн инженерийн нэг нь мэргэшсэн нөгөө нь зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв /тухайн ажлын төрлийн хүрээнд/	Төсөвчин-2	Төсөв үнэлгээний мэргэжилтний нэг нь мэргэшсэн зэрэгтэй байна.
11. Өргөх байгууламжийн эд анги үйлдвэрлэлийн зураг төсөл		
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршилага
ЗТ-11.1 Машин, тоног төхөөрөмж, түүний эд ангийн үйлдвэрлэлийн зураг төсөл, кранаар ажил гүйцэтгэх төсөл	Механик инженер-2 Цахилгааны инженер-1	Механик инженерийн аль нэг нь барилгын материалын үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийн ашиглалтын мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилгын материалын үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийн ашиглалтын зөвлөх зэрэгтэй байх. Цахилгааны инженер нь барилга байгууламжийн цахилгаан хангамжийн системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх.

ХОЁР. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН УГСРАЛТ, ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД			
Суурь нөхцөл, шаардлага:			
1. Барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил			
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА-ын ажлын туршилага	Байвал зохих мэргэжилтэй ажилтан
БА-1.1 Зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламжийн зураг төсөл	Шаардахгүй	Шаардахгүй	Шаардахгүй
2. Бага төвөгшилтэй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил			
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА ажлын туршилага	Байвал зохих мэргэжилтэй ажилтан
БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил[9]	Барилгын инженер-1 ХАБЭА-1	Барилгын инженер нь мэргэжлээрээ 2-аас доошгүй жил ажилласан байх	Бетон арматурчин-1 Барилга угсралтын ажилтан-2
БА-2.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил[10]	Усны барилга байгууламжийн буюу усны нөөцийн инженер-1 ХАБЭА-н ажилтан-1	Усны барилга байгууламжийн инженер нь мэргэжлээрээ 5-с доошгүй жил ажилласан туршлагатай байх	Барилга угсралтын ажилчин-2
3. Дунд төвөгшилтэй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил			
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА ажлын туршилага	Байвал зохих мэргэжилтэй ажилтан
БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил[11]	Барилгын инженер- 2 ХАБЭА-н ажилтан-1	Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн угсралт, засварын мэргэшсэн зэрэгтэй байх.	Бетон арматурчин-2, Барилга угсралтын ажилтан-3
БА-3.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил[12]	Усны барилга байгууламжийн буюу усны нөөцийн инженер-2 ХАБЭА-н ажилтан-1	Усны барилга байгууламжийн аль нэг инженер нь усны барилга байгууламжийн угсралт засварын ажлын хүрээнд мэргэшсэн зэрэгтэй байх ХАБЭА-н ажилтнаар 1-с доошгүй жил ажилласан туршлагатай байх	Бетон, арматурчин-1 Барилга угсралтын ажилчин-2
БА-3.3 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт[13]	Ус хангамж ариутгах татуургын инженер-2 ХАБЭА-н ажилтан-1	Ус хангамж, ариутгах татуургын аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байх ХАБЭА-н ажилтнаар 1-с доошгүй жил ажилласан туршлагатай байх	Сантехникч-2, Гагнуурчин-2
БА.-3.4. Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт	Дулааны инженер-2 ХАБЭА-н ажилтан-1	Дулааны аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй ХАБЭА-н ажилтнаар 1-с доошгүй жил ажилласан туршлагатай байх	Гагнуурчин-2 засварчин-2
БА-3.5. Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног	Цахилгааны инженер-2 ХАБЭА-н ажилтан-1	Цахилгааны инженерийн аль нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх ХАБЭА-н ажилтнаар 1-с доошгүй жил ажилласан	Цахилгаанчин -4

төхөөрөмжийн угсралт		туршлагатай байх	
БА-3.6 Газрын тосны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, орчны тохижилтын ажил	Газрын тосны барилга байгууламжийн инженер-1 Цахилгааны инженер-1 Халаалт, агаар сэлгэлтийн инженер-1 Хийн хангамжийн инженер-1 ХАБЭА-н ажилтан-1	Газрын тосны барилга байгууламжийн инженер нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн угсралт, засварын чиглэлээр 5-с доошгүй жил ажилласан туршлагатай байх ХАБЭА-н ажилтнаар 2-с доошгүй жил ажилласан туршлагатай байх	Цахилгаан гагнуурчин-2, Хийн гагнуурчин-1 Бетон арматурчин-2, Барилга угсралтын ажилтан-2
4. Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил			
Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА ажлын туршилага	Байвал зохих мэргэжилтэй ажилтан
БА-4.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил [14]	Барилгын инженер-3 ХАБЭА-н ажилтан-2	Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн угсралт, засварын мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилга байгууламжийн угсралт, засварын зөвлөх зэрэгтэй-1 тус тус байна. ХАБЭА-н ажилтнаар 3-с доошгүй жил ажилласан туршлагатай байх.	Бетон арматурчин-3, Өрлөгчин-2, Барилга угсралтын ажилтан-2
БА-4.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил [15]	Усны барилга байгууламжийн буюу усны нөөцийн инженер 3 ХАБЭА-н ажилтан-2	Усны барилга байгууламжийн инженер нь аль нэг нь усны барилга байгууламжийн угсралт засварын мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь усны барилга байгууламжийн угсралт, засварын зөвлөх зэрэгтэй байх. ХАБЭА-н ажилтнаар 3-с доошгүй жил ажилласан туршлагатай байх.	Бетон, арматурчин-2 Барилга угсралтын ажилтан-3 Гагнуурчин-1
БА-4.3 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт [16]	Ус хангамж, ариутгах татуургын инженер-2 Механик инженер-1 Барилгын инженер-1 Цахилгааны инженер-1 ХАБЭА-2	Ус хангамж, ариутгах татуургын инженерийн аль нэг нь ус хангамж, ариутгах татуургын системийн угсралт, засварын мэргэшсэн зэрэгтэй байх. ХАБЭА-н ажилтнаар 3-с доошгүй жил ажилласан туршлагатай байх.	Сантехникч-3 Гагнуурчин-3
	Лаборант-техник технологич-1	Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх
МУ-8.3.2 Галд гэсвэртэй керамик эдлэлийн үйлдвэр	2 сая ш. дээш жилд хүч чадалтай	Дунд хүчин чадалтай
	Технологи инженер-1 Механик инженер-1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг тушаалаар томилж ажиллуулна.
	Цахилгааны инженер-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологич инженер нь мэргэшсэн зэрэгтэй байх.
	Лаборант-техник технологич-1 (ээлжийн тооноос хамаарна)	Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх
9. Дээврийн материал		
Үйлдвэрлэлийн чиглэл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА ажлын турилгаа
МУ-9.1 Дээврийн хуйлмал, зүймэл / металл, металл бус бетон, Нано технологийн, / материалын үйлдвэр	Технологи инженер-1	Үйлдвэрлэлийн хүч чадлаас хамаарч Цахилгааны инженерийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.
	Механик инженер-1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг тушаалаар томилж ажиллуулна.
	Цахилгааны инженер-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1	Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх.
	Лаборант-техник технологич-1	
10. Шалны материал		
Үйлдвэрлэлийн чиглэл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА ажлын турилгаа
МУ-10.1 Шалны бүх төрлийн материалын үйлдвэр.	Технологи инженер-1	Үйлдвэрлэлийн хүч чадлаас хамаарч Цахилгааны инженерийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.
	Механик инженер-1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг тушаалаар томилж ажиллуулна.
	Цахилгааны инженер-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1	Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх.
	Лаборант-техник технологич-1	
11. Эрчим хүчний хэмнэлттэй цонх, барилгын материал, хийц, эдлэл* [21]		
Үйлдвэрлэлийн чиглэл	Байвал зохих инженер техникийн ажилтан	ИТА ажлын турилгаа
МУ-11.1 Эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалын үйлдвэр	Технологи инженер-1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг тушаалаар томилж ажиллуулна.
	Механик инженер-1	Цахилгааны инженерийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.
	Цахилгааны инженер-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1	Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх.
		Эрчим хүчний аудит хийлгэсэн байх
МУ-11.1.1 Барилгын Цонх, хаалга, үйлдвэрлэл	Халаалтын улирлын хэм хоног (ХУХХ) бүсчлээр,	Дулааны дамжуулалтын эсэргүүцлийн хязгаар R, м2 °C/Вт
		Цонхны анги

	Барилгын зориулалтын анги 1/		
	I	0.65	T-4 дээш
	II	0.63	T-4 дээш
	III	0.6	T-5 дээш
	IV	0.55	T-6 дээш
	Технологи инженер-1 Механик инженер-1 Цахилгааны инженер-1 Цонхны операторчин -1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг тушаалаар томилж ажиллуулна. Цахилгааны инженерийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно. Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх. Эрчим хүчний аудит хийлгэсэн байх
МҮ-11.1.2 Хуванцар бэлдэц цувимал үйлдвэрлэл	Дулаан дамжуулалтын эсэргүүцэл 0.65 буюу түүнээс дээш ($m^2 \text{ } ^\circ\text{C}$)/ Вт		
	Механик инженер-1 Цахилгааны инженер-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг тушаалаар томилж ажиллуулна. Цахилгааны инженерийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно. Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх.
МҮ-11.1.3 Эрчим хүчний хэмнэлттэй шилэн багцын үйлдвэрлэл	Дулаан дамжуулалтын эсэргүүцэл 0.65 буюу түүнээс дээш ($m^2 \text{ } ^\circ\text{C}$)/ Вт		
	Механик инженер-1 Цахилгааны инженер-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг тушаалаар томилж ажиллуулна. Цахилгааны инженерийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно. Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх.
МҮ-11.1.4 Барилгын шилэн фасад	Дулаан дамжуулалтын эсэргүүцэл 0.65 буюу түүнээс дээш ($m^2 \text{ } ^\circ\text{C}$)/ Вт		
	Механик инженер-1 Цахилгааны инженер-1 Цонхны операторчин -1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг тушаалаар томилж ажиллуулна. Цахилгааны инженерийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно. Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон хүрэлцэхүйц тооны мэргэжилтэй ажилчидтай байх.

---oOo---

“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын 2 дугаар хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

“.....”

“.....”

ХХК-ИЙН ЗАХИРАЛ

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АСУУДЛЫГ ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ХАРИУЦАГЧ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

20... оны ... дугаар сарын...-ны өдөр

Дугаар:....

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зураг төсөл боловсруулах, барилгын ажил, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэхээр барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан (цаашид “БҮАТЗ эзэмшигч” гэнэ) аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “ААНБ” гэнэ) бүр нь(цаашид “БҮАТЗ олгогч” гэнэ)-тай энэхүү гэрээг байгуулж ажиллана.
- 1.2. Хоёр тал нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад холбогдох тогтоомжийн хүрээнд энэхүү гэрээг байгуулж, хууль тогтоомжид заагдсан эрх, үүргийг хүлээнэ.
- 1.3. Гэрээний үндсэн зорилго нь тусгай зөвшөөрөл олгогч, эзэмшигч хоёр тал нь хууль эрх зүйн хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагыг хамтран хэрэгжүүлэхэд оршино.
- 1.4. БҮАТЗ олгогчийг төлөөлж:/Байгууллагын нэр//албан тушаал/.....овог.....нэр
- 1.5. БҮАТЗ эзэмшигчийг төлөөлж: “.....” ХХК-ийн/Албан тушаал/.....овогтойнар нь Барилга, хот байгуулалтын сайдын 20... оны ...дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгогчийн эрх, үүрэг

- 2.1. Барилгын салбарт нийтлэг мөрдөх хууль тогтоомж, журам, заавар, зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд мөрдөх эрх зүйн акт, норм норматив, техникийн баримт бичгүүдийн талаарх мэдээ, мэдээллээр шуурхай хангаж ажиллах;
- 2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд нь авч, мэдээллийн санд нэгтгэн тухайн салбарын ААНБ-уудын үйл ажиллагаанд дүн шинжилгээг хийж тэдний ажил, үйлчилгээний талаар тодорхойлолтыг гаргаж өгөх, салбарын бодлого, чиглэлийг боловсруулахад ашиглах;
- 2.3. Барилгын салбарын норм, дүрэм, заавар, стандартыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх, норм нормативын баримт бичгийг боловсруулахад зарцуулах хөрөнгийг төвлөрүүлэх.
- 2.4. Мэргэжил дээшлүүлэх, гадаад, дотоодын ижил төстэй ажил, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын туршлагыг судлах, дадлага хийх, үзэсгэлэн, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулах, үйл ажиллагаагаа өргөтгөхөд мэргэжлийн туслалцаа дэмжлэгийг үзүүлэх.
- 2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн албан бичгийн холбогдох бичиг баримтыг үндэслэн инженер, техникийн ажилтнууд (цаашид “ИТА”)-ын шилжилт хөдөлгөөнийг мэдээллийн санд бүртгэх.
- 2.6. Мэргэжлийн хяналтын байгууллага, иргэдийн мэдээллийн дагуу илэрсэн зөрчил, дутагдлыг мэдээллийн нэгдсэн сангийн “Тусгай бүртгэл”-д бүртгэх, энэ талаар тухайн ААНБ-дад албан бичгээр мэдэгдэх, зөрчлийг арилгах талаар хийсэн ажлын үр дүнг харгалзан бүртгэлээс хасах, тендерийн хороо, үнэлгээний хэсэгт энэ талаар мэдээллийг өгөх.
- 2.7. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг ажлын албаар шийдвэрлүүлэн, харьяалах татварын алба, мэргэжлийн хяналтын байгууллагуудад мэдэгдэж, нийтэд мэдээлэх.
- 2.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийж, удирдамж, чиглэлийг өгөх.
- 2.9. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй, хуанлийн 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд олгогдсон Тусгай зөвшөөрөл хүчингүйд тооцож, нийтэд мэдээлэх.
- 2.10. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй, Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн нөхцөлд БҮАТЗ-ийг хүчингүй болгох саналыг оруулах.
- 2.11. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг зориулалт бусаар ашигласан, хуурамчаар үйлдсэн, засварласан, бусдад шилжүүлсэн, барьцаалсан, Тусгай зөвшөөрлийг сунгуулахдаа хуурамчаар бичиг баримт бүрдүүлсэн нь нотлогдсон тохиолдолд БҮАТЗ-ийг нь цуцлах саналыг оруулах.
- 2.12. Тусгай зөвшөөрөлд заагаагүй ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн, ИТА нь ажлаас чөлөөлөгдсөний улмаас “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-д заасан суурь нөхцөл шаардлагыг хангахгүй болсон, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны улмаас хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан бол олгогдсон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгох саналыг оруулах.
- 2.13. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү гэрээний 3.2-т заасан үүргээ биелүүлээгүй, барилгын салбарын статистик мэдээ, үйл ажиллагааны тайлангаа 1 жилээс дээш хугацаанд мэдээллийн санд ирүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

- 3.1. БҮАТЗ-ийн нөхцөл шаардлагыг хангаж, олгогдсон хүрээнд заасан ажил, үйлчилгээг эрхлэх.
- 3.2. Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 206, А/184 дугаартай тушаалаар батлагдсан барилгын салбарын бүртгэл, мэдээллийн маягтаар барилгын үйл ажиллагааны тайлан мэдээг жилд 2 удаа буюу хагас жилийн байдлаар тухайн оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор www.mcis.gov.mn цахим системээр ирүүлнэ. (үйл ажиллагаа явуулаагүй бол үйл ажиллагааны тайланг “Х” –ээр ирүүлнэ).
- 3.3. БҮАТЗ эзэмшигч, удирдлага, ерөнхий болон талбайн инженер, даамал зэрэг удирдах гол мэргэжилтнүүд нь ажлаас чөлөөлөгдөх, суурин утас, факс, и-мэйл хаяг, шуудангийн хаяг өөрчлөгдвөл энэ тухайгаа БҮАТЗ олгогчид нэн даруй мэдэгдэх;
- 3.4. Барилгын тухай хууль болон “Барилгын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журам”-д заасны дагуу Норм, нормативын санд төвлөрүүлэх хөрөнгийг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Худалдаа хөгжлийн банкны 26 000 78 533 тоот дансанд шилжүүлэх;
- 3.5. БҮАТЗ эзэмшигч нь “БҮАТЗ”-ийг авснаас хойш ажлын 7 хоногийн дотор харьяалагдах татварын албанд эрхлэх үйл ажиллагааны чиглэлээ бүртгүүлсэн байх;
- 3.6. БҮАТЗ-д заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай норм, дүрэм, стандарт, журам, заавар, альбом, каталог, хууль тогтоомж, дүрэм журмын эмхэтгэл зэрэг техникийн баримт бичгүүдийн фондыг тогтмол баяжуулах;

- 3.7. Ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээг байгуулахдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (цаашид “ХАБЭА” гэнэ) нөхцөлийн талаарх заалтыг тусгаж, мөрдөх (ажил олгогч, ажил гүйцэтгэгч нарын хөдөлмөр хамгааллын талаар харилцан хүлээх эрх, үүргийг тодорхой тусгах), аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;
- 3.8. Барилгын үйлдвэрлэлд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй ажиллагааг бүрэн хангаж хариуцан ажиллах;
- 3.9. Үйлдвэрлэл, үйлчилгээгээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд барилгын норм, дүрэм стандартыг мөрдөн чанартай явуулах бөгөөд хэрэглэгчдийн эрх ашгийг хохироохгүй байх;
- 3.10. БҮАТЗ олгогч байгууллагатай байнгын холбоотой байж, БҮАТЗ олгогчоос зохион байгуулж буй бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, ИТА-уудаа бүрэн хамруулж мэргэжлийн ур чадварыг байнга дээшлүүлж байх;
- 3.11. Гүйцэтгэж буй ажил, үйлчилгээндээ дотоодын хяналтыг тогтмол ажиллуулж, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтыг хийлгүүлж, дүгнүүлж ажиллах;
- 3.12. Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 107 дугаар тушаалаар баталсан Насанд хүрээгүй хүн ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт тус бүрийг мөрдлөг болгон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох;

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн гэрээний хариуцлага

- 4.1. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 17.1 дүгээр заалтын дагуу тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг нь эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.
- 4.2. БҮАТЗ-ийн Гэрээг байгуулсан хоёр талын аль нэгийн санаачилгаар гэрээг цуцлах болбол 14-оос доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.
- 4.3. БҮАТЗ-ийн Гэрээ нь БҮАТЗ-ийн Гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд БҮАТЗ олгогдсон, сунгагдсан өдрөөс эхлэн 5 (таван) жилийн хугацаанд хүчинтэй байна. БҮАТЗ нь цуцлагдсан, түдгэлзүүлсэн шийдвэр гарсан өдрөөс эхлэн гэрээг хүчингүй болсонд тооцно.

Тав. Гэрээний тусгай гэмдэглэл

- 5.1. Тушаалаар олгогдсон ажлын төрлийн заалт:
- 5.2. Эзэмшигчийн байршил, хаяг:

Утас:.....Факс:.....E-майл хаяг:.....

Гэрээ байгуулсан:

Тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлж:	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:
.....
.....
/...../	/...../
Утас:.....	Утас:.....

---oOo---

БАТЛАВ.

“.....”

БАТЛАВ.

“.....”

ХХК-ИЙН ЗАХИРАЛ

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АСУУДЛЫГ

ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ХАРИУЦАГЧ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

20... оны сарын өдөр Дугаар:... Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр барилгын материалын үйлдвэрлэл эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан /цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэнэ/ аж ахуйн нэгж, байгууллага бүр /цаашид “тусгай зөвшөөрөл олгогч” гэнэ/-той энэхүү гэрээг байгуулж ажиллана.
- 1.2. Хоёр тал нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд энэхүү гэрээг байгуулж, хууль тогтоомжид заагдсан эрх, үүргийг хүлээнэ.
- 1.3. Гэрээний үндсэн зорилго нь тусгай зөвшөөрөл олгогч, эзэмшигч хоёр тал хууль эрх зүйн хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагаа хамтран хэрэгжүүлэхэд оршино.
- 1.4. БМҮТЗ олгогчийг төлөөлж:/Байгууллагын нэр//албан тушаал/.....овог.....нэр
- 1.5. БМҮТЗ эзэмшигчийг төлөөлж: “.....” ХХК-ийн/Албан тушаал/.....овогтойнар нь Барилга, хот байгуулалтын сайдын 20... оны ...дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгогчийн эрх, үүрэг

- 2.1. Барилгын салбарт нийтлэг мөрдөх хууль тогтоомж, журам заавар зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд мөрдөх эрх зүйн акт, норм норматив, техникийн баримт бичгүүдийн талаархи мэдээ, мэдээллээр шуурхай хангаж ажиллах;
- 2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд авч, мэдээллийн санд нэгтгэн тухайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, тэдний ажил үйлчилгээний талаар тодорхойлолт гаргаж өгөх, салбарын бодлого чиглэл боловсруулахад ашиглах;
- 2.3. Мэргэжил дээшлүүлэх, гадаад, дотоодын ижил төстэй ажил, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын туршлага судлах, дадлага хийх, үзэсгэлэн семинар, зөвлөгөөн зохион байгуулах, үйл ажиллагаа өргөтгөхөд нь мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх;
- 2.4. Мэргэжлийн хяналтын байгууллага, иргэдийн мэдээллийн дагуу илэрсэн зөрчил дутагдлыг мэдээллийн нэгдсэн сан /тусгай бүртгэл/-д бүртгэх, энэ талаар тухайн байгууллага, аж ахуйн нэгжид албан бичгээр мэдэгдэх, зөрчлийг арилгах талаар хийсэн ажлын үр дүнг харгалзан бүртгэлээс хасах, тендерийн хороо, үнэлгээний хэсэгт энэ талаар мэдээлэл өгөх, “Тусгай зөвшөөрөл”-ийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг ажлын албаны хуралд оруулж шийдвэрлүүлэн, харьяалах татварын алба, мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, нийтэд мэдээлэх;
- 2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийж, удирдамж чиглэл өгөн мэдээ тайланг хугацаанд нь авч байх;
- 2.6. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй хуанлийн 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцож зарлах;
- 2.7. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг удаа дараа зөрчсөн нөхцөлд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал хүргүүлэх;
- 2.8. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг зориулалтын бусаар ашигласан, хуурамчаар үйлдсэн, засварласан, бусдад шилжүүлсэн, барьцаалсан, тусгай зөвшөөрөл сунгуулахдаа хуурамчаар бичиг баримт бүрдүүлсэн нь нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг нь цуцлах санал оруулах;
- 2.9. Тусгай зөвшөөрөлд заагаагүй ажил үйлчилгээ гүйцэтгэсэн тохиолдолд олгогдсон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгох, энэ тухай мэргэжлийн хяналтын байгууллага, харьяалах татварын албанд мэдэгдэж, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 18.1.1-д заасны дагуу арга хэмжээ авах;
- 2.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн тайланг үндэслэн инженер техникийн ажилтны шилжилт хөдөлгөөнийг мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулна.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

- 3.1. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж, олгогдсон хүрээнд заасан ажил үйлчилгээ эрхлэх;
- 3.2. Энэхүү гэрээний хавсралт маягтуудын дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл ажиллагааны мэдээ, тайланг /БХБ-ын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 206, А/184 тоот тушаалын хавсралт 3-БМ-1, 3-БМ-2, 3-БХБЯ-1, 3-БХБЯ-2 маягтуудын дагуу мэдээ, тайлангаа хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлнэ. (үйл ажиллагаа явуулаагүй бол үйл ажиллагааны тайланг “Х” –ээр ирүүлнэ).
- 3.3. Тохирлын гэрчилгээний сунгалтыг хүчинтэй заасан хугацаанд тогтмол хийж, мэдээллийг ирүүлэх;
- 3.4. Зөвлөх болон мэргэшсэн, бусад инженер, техникийн ажилтны шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийн тэмдэглэл /суурин утас, факс, Е-майл хаяг, шуудангийн хаяг/-ийг тусгай зөвшөөрөл олгогчид мэдэгдэж, тэмдэглэлийг хийлгэх;
- 3.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Тусгай зөвшөөрөл” авснаас хойш ажлын 7 хоногийн дотор харьяалагдах татварын албанд эрхлэх үйл ажиллагааны чиглэлээ бүртгүүлсэн байх;
- 3.6. Тусгай зөвшөөрөлд заасан ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай норм, дүрэм, заавар, журам, альбом, каталоги, стандарт зэрэг техникийн баримт бичгүүдийг баримтлан ажиллаж, фондыг тогтмол баяжуулах;
- 3.7. Ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийн талаархи заалтыг тусгаж, мөрдөх /ажил олгогч, ажил гүйцэтгэгч нарын хөдөлмөр хамгааллын талаар харилцан хүлээх эрх, үүргийг тодорхой тусгах/, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи дүрэм журмыг баримталж ажиллах;
- 3.8. Ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, амь насны болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах;
- 3.9. Үйлдвэрлэл, үйлчилгээндээ техникийн болон бүтээгдэхүүний чанарын дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж барилгын норм, дүрэм, стандартыг мөрдөн, хэрэглэгчдийн эрх ашгийг хохироохгүй байх;
- 3.10. Зөвшөөрөл олгогч байгууллагын зүгээс зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд идэвхитэй оролцох, сургалт, үзлэг шалгалтанд инженер техникийн ажилтнаа бүрэн хамруулж, удирдамж чиглэл авах;
- 3.11. Мэргэжлийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагсадыг дадлага хийх нөхцөлөөр хангаж, жилд “...”-аас доошгүй оюутныг дадлагажуулсан байх;
- 3.12. Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 107 дугаар тушаалаар баталсан Насанд хүрээгүй хүн ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт тус бүрийг мөрдлөг болгон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох;

Дөрөв. Гэрээг цуцлах хугацаа, үндэслэл

- 4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй /тайлан мэдээгээ 2 улирлаас дээш хугацаанд ирүүлээгүй, технологи үйл ажиллагааны хувьд ноцтой зөрчил гаргасан, хэрэглэгчээс гарсан гомдол, саналд тулгуурлан хийсэн шалгалт гэх мэт/ тохиолдолд гэрээг цуцлах буюу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудал тавигдана. Гэрээг цуцлахаар бол 14-өөс доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.
- 4.2. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 17.1 дүгээр заалтын дагуу тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг нь эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.
- 4.3. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд тусгай зөвшөөрөл олгогдсон, сунгагдсан өдрөөс цуцлагдах хүртэл хугацаанд хүчинтэй байна.

Тав. Гэрээний тусгай тэмдэглэл

5.3. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон ажлын төрлийн заалт:

5.4. Эзэмшигчийн байршил, хаяг:

Утас: Факс: Е-майл хаяг:

Гэрээ байгуулсан:

Тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлж: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

Компанийн

.....

.....

/...../

/...../

Утас:.....

Утас:

---oOo---

“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР,

ТОДОРХОЙЛОЛТ

1. “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх этгээдэд олгох тусгай зөвшөөрлийн гэрчилгээ /цаашид “гэрчилгээ” гэх/-ний загварыг тодорхойлов.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.7-д заасныг тусгасан байна. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг бусад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь 4 шатлал бүхий нууцлалтай, үнэт цаас байна.
4. Гэрчилгээний загварыг тодорхойлолтод хавсаргав.

ГЭРЧИЛГЭЭНИЙ НҮҮРЭН ТАЛ, АГУУЛГА

5. Гэрчилгээний өргөн нь 22 см, урт нь 30 см 5 мм байна.
6. Гэрчилгээний дэвсгэр С-51%, М-2%, Ү-7%, К-0% кодын цэнхэр өнгөтэй байх ба 11 мм-ийн өргөнтэй С-100%, М-52%, Ү-20%, К-31% кодын цайвар цэнхэр өнгийн сүлжмэл хээн хүрээтэй байна.
7. Гэрчилгээний дээд хэсэгт 22.5x45 мм хэмжээтэй соёмбыг байрлуулна. Соёмбо нь MNS6262:2011 стандартад заасан шаардлагыг хангасан байна.
8. Соёмбын хажуу талд Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар байна.
9. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаарыг 7-н оронтой /00-000/00/ тоогоор тэмдэглэж, ангилал, кодыг оруулах ба 00- аймаг, дүүргийн код, 000- тухайн жилд олгогдож буй тусгай зөвшөөрлийн дугаар, 00- тусгай зөвшөөрөл олгогдсон оныг илэрхийлнэ.
10. Соёмбын доод талд тусгай зөвшөөрөл олгосон Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрсийг С-100%, М-52%, Ү-20%, К-31% кодын хөх өнгөөр, том үсгээр (Arial bold, үсгийн хэмжээ 24) бичсэн байна.
11. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийн доод талд, С-51%, М-2%, Ү-7%, К-0% кодын хөх өнгөөр том үсгээр (Arial bold, үсгийн хэмжээ 96) **“ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ”** гэсэн гарчиг байх ба түүний доод талд тусгай зөвшөөрлийн дугаарыг бичнэ.
12. Аж ахуйн үйл ажиллагааны төрлийг товчлол үсгээр илэрхийлж “БУ”- Барилга угсралт, “ЗТ”- Зураг төсөл, “ӨБ”- Өргөх байгууламж гэсэн утгаар ойлгож тусгай зөвшөөрлийн дугаарын эхэнд бичнэ.
13. Гэрчилгээ нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийг үндэслэнаймаг /нийслэл/-ийнсум /дүүрэг/-ийн-дажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийгоныдугаар сарынны өдрөөсжилийн хугацаатай олгов. “Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй” гэсэн өгүүлбэр бүхий бичвэртэй байна.
14. Гэрчилгээний доод талд гэрчилгээ олгосон Барилга, хот байгуулалтын сайдын нэр, олгосон огноо, олгосон газрыг бичсэн байна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ АР ТАЛ, АГУУЛГА

15. Гэрчилгээний дээд хэсэгт “Ажил үйлчилгээний төрөл:” гэснийг жижиг үсгээр, доод хэсэгт Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг.....Компанийн захирал /эзэн/..... Утас:.....Факс:.....E-mail:..... өгүүлбэр бүхий бичвэртэй байна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТЫН НҮҮРЭН ТАЛ, АГУУЛГА

- 16. Гэрчилгээ нь хавсралттай байх бөгөөд хавсралт нь гэрчилгээний салшгүй хэсэг байна.
- 17. Хавсралтын баруун дээд талд “Гэрчилгээний хамт хүчинтэй” гэсэн бичиглэл, түүний доод талд “ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ” гэсэн гарчиг, түүний доод талд “Нэмэлт өөрчлөлт” гэсэн бичвэр бичигдэнэ.
- 18. Хавсралтын доод талд баталгаажуулсан Барилга, хот байгуулалтын сайдын нэр, нэмэлт өөрчлөлтийг оруулсан “огноо”-г оруулна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТЫН АР ТАЛ, АГУУЛГА

19. Хавсралтын дээд талд Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэр, түүний доод талд Барилгын тухай хуулийн 34.1-д заасан байгууллагын нэр, түүний доод талд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг жил бүр дүгнэсэн тухай тэмдэглэл, гэрээ дүгнэсэн албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тэмдэгийг дарах зориулалттай хүснэгт байх ба гэрээ дүгнэсэн огноо, тэмдэглэгээ хийсэн албан тушаалтны нэр, баталгаажуулсан “тэмдэг”-ийг дарсан байна.

---oOo---



Ажил үйлчилгээний төрөл:

САЙД..... /

..... оны-р сарын өдөр

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг:.....

Компанийн захирал /эзэн/.....

Утас:..... Факс:..... төвөгшөөгч E-mail:.....

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Гэрээ дүгнэсэн тэмдэглэл	Албан тушаалтны гарын үсэг, тэмдэг

..... дугаар гэрчилгээний хавсралт
Гэрчилгээний хамт хүчинтэй.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

Нэмэлт өөрчлөлт:

САЙД..... / /

“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын 4 дүгээр хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,

ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

1. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйлчилгээний суурь хөлсний хэмжээг 420,000 /дөрвөн зуун хорин мянган/ төгрөг байна.
2. Үйл ажиллагаа эрхлэх ажлын төрлөөс хамаарсан нэмэлт хөлсийг дараах байдлаар тогтоож, тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгалт хийлгэх, нэмэлт ажлын төрөл авах тохиолдолд дараах байдлаар тогтооно.

Д/д	Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал болон	Үйлчилгээний нэмэлт
-----	--	---------------------

	хүчин чадлын төрөл	хөлсний хэмжээ /төгрөгөөр/
Нэг. Зураг төсөл боловсруулах чиглэлээр		
1.	Бага төвөгшилтэй	50,000
2.	Дунд төвөгшилтэй	100,000
3.	Өндөр төвөгшилтэй	150,000
4.	Онцгой төвөгшилтэй	200,000
5.	Тухайлсан	250,000
Хоёр. Барилгын ажил гүйцэтгэх чиглэлээр		
1.	Бага төвөгшилтэй	100,000
2.	Дунд төвөгшилтэй	150,000
3.	Өндөр төвөгшилтэй	200,000
4.	Онцгой төвөгшилтэй	300,000
5.	Тухайлсан	350,000
Гурав. Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний чиглэлээр		
1.	Дунд төвөгшилтэй	50,000
2.	Өндөр төвөгшилтэй	100,000
3.	Онцгой төвөгшилтэй	200,000
Дөрөв. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр		
1.	Бага хүчин чадалтай	50,000
2.	Дунд хүчин чадалтай	100,000
3.	Өндөр хүчин чадалтай	150,000

Тайлбар:

1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах “дунд” төвөгшилд ЗТ-6, ЗТ-10, ЗТ-11, ЗТ-12-ын заалтууд хамаарна.
2. Барилга байгууламжийн ажил гүйцэтгэх “дунд” төвөгшилд БА-6-ын заалт хамаарна.
3. Барилгын материалын үйлдвэрлэлийн МУ-3.3, 3.4, 3.5 болон 7, 9, 10-ын заалтуудад хамаарах тусгай зөвшөөрөл нь “дунд” хүчин чадалтайд хамаарна.
4. Барилгын материалын үйлдвэрлэлийн 11 дэх заалтад хамаарах эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалын үйлдвэрийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээний суурь хураамж 200,000 төгрөг байна.

-----oOo-----

[1] Барилга байгууламжийн төвөгшилтийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний, авто машины зогсоолын, цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж, хөдөө аж ахуйн зориулалттай, түр барилга байгууламжуудын зураг төсөл багтсан.

[2] Барилга байгууламжийн төвөгшилтийн ангилалд хамаарах 100 га хүртэл усалтын систем, 100 мян.га хүртэлх усан мандлын талбайтай хөв цөөрмийн барилга байгууламж, 1000м²/га хүртэлх барилгын нягттай хот суурины борооны ус зайлуулах систем, ХАА болон бэлчээр усжуулалтын уст цэгүүд, инженерийн хийцтэй усан оргилуурууд багтана.

[3] Барилга байгууламжийн төвөгшилтийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, мэдээлэл, холбоо-сүлжээний барилга байгууламж, худалдаа, үйлчилгээний, авто машины зогсоолын, цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж, хөдөө аж ахуйн зориулалттай, түр барилга байгууламжуудын зураг төсөл багтсан.

[4] “Барилга байгууламжийн төвөгшилтийн ангилалд хамаарах БНбД33-01-03-р тодорхойлогдох III-IV ангийн усны үндсэн барилга байгууламжууд (усан цахилгаан станцын барилга хамаарахгүй), мөн ангид хамаарах хаягдлын байгууламжууд, 100 м³/х хүртэлх хүчин чадалтай ус татамжийн барилга байгууламжууд багтана”

[5] Барилга байгууламжийн төвөгшилтийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, мэдээлэл, холбоо-сүлжээний барилга байгууламж, худалдаа, үйлчилгээний, авто машины зогсоолын, цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил барилга байгууламжуудын зураг төсөл багтсан.

[6] Барилга байгууламжийн төвөгшилтийн ангилалд хамаарах БНбД33-01-03-р тодорхойлогдох II- ангийн усны үндсэн барилга байгууламжууд II-IV а нгийн усан цахилгаан станцын барилга, дулаан цахилгаан станцын усны барилга байгууламжууд, /хөргөлтийн систем, үнсэн сан, эргэлтийн усны систем/, 101м³ /х дээш багтаамжтай ус татамжийн барилга байгууламжууд багтана.

[7] Барилга байгууламжийн төвөгшилтийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, авто машины зогсоолын, цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил барилга байгууламжуудын зураг төсөл багтсан.

[8] Барилга байгууламжийн төвөгшилтийн ангилалд хамаарах БНбД33-01-03-р тодорхойлогдох I ангийн усны үндсэн барилга байгууламжууд, I ангийн усан цахилгаан станцын барилга, атомын цахилгаан станцын усны барилга байгууламжууд (хөргөлтийн систем, үнсэн сан, эргэлтийн усны систем) багтана.

[9] Барилга байгууламжийн төвөгшилтийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний, үйлдвэрийн барилга байгууламж, агуулах, авто машины зогсоолын, цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж, хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламжуудын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажлууд багтсан.

[10] Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах 100 га хүртэлх усралтын систем, 100 мян.га хүртэлх усан мандлын талбайтай хөв цөөрмийн барилга байгууламж, 1000 м2/га хүртэлх барилгын нягттай хот суурингийн борооны ус зайлуулах систем, ХАА болон бэлчээр усжуулалтын уст цэгүүд, инженерийн хийцтэй усан оргилуурууд багтана.

[11] Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний, үйлдвэрийн барилга байгууламж, агуулах, мэдээлэл, холбоо-сүлжээний барилга байгууламж, авто машины зогсоолын цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж, хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламжуудын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажлууд багтсан.

[12] Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах БНбД33-01-03-р тодорхойлогдох III-IV ангийн усны үндсэн барилга байгууламжууд (усан цахилгаан станцын барилга хамаарахгүй), мөн ангид хамаарах хаягдлын байгууламжууд, 100м3/х хүртэл хүчин чадалтай ус татамжийн барилга байгууламжууд багтана.

[13] Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын бага болон дунд төвөгшилтэй ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн угсралтын ажлууд багтсан.

[14] Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний, үйлдвэрийн барилга байгууламж, агуулах, мэдээлэл, холбоо-сүлжээний барилга байгууламж, авто машины зогсоолын цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж, хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламжуудын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажлууд багтсан.

[15] Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах БНбД33-01-03-р тодорхойлогдох II ангийн усны үндсэн барилга байгууламжууд, II-IV ангийн усан цахилгаан станцын барилга, дулааны цахилгаан станцын усны барилга байгууламжууд мөн ангид хамаарах хаягдлын байгууламжууд (хөргөлтийн систем, үнсэн сав, эргэлтийн усны систем), 101м3/х дээш багтаамжтай ус татамжийн барилга байгууламжууд багтана.

[16] Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын өндөр төвөгшилтэй ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн угсралтын ажлууд багтсан.

[17] Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын өндөр зэргийн төвөгшилтэй газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламж, (10000м³ хүртэл багтаамжтай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн ачих, шилжүүлэх байгууламж, дамжуулах шугам, хийн цооногийн байгууламж, гарын тос, хий, ус цуглуулах, тээвэрлэх объектын барилга гм)-ийн угсралтын ажлууд багтсан.

[18] Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, үйлдвэрийн барилга байгууламж, агуулах, авто машины зогсоолын цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламжуудын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажлууд багтсан.

[19] Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах БНбД33-01-03-р тодорхойлогдох I ангийн усны үндсэн барилга байгууламжууд, I ангийн усан цахилгаан станцын барилга, атомын цахилгаан станцын усны барилга байгууламжууд (хөргөлтийн систем, үнсэн сан, эргэлтийн усны систем) багтана.

[20] Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын өндөр зэргийн төвөгшилтэй газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламж, (10001м³-ээс дээш хүртэл багтаамжтай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн ачих, шилжүүлэх байгууламж, дамжуулах шугам, хийн цооногийн байгууламж, гарын тос, хий, ус цуглуулах, тээвэрлэх объектын барилга гм)-ийн угсралтын ажлууд багтсан.

[21] Эрчим хүчний хэмнэлттэй материал, хийц, эдлэлийн техник-технологийн үзүүлэлтийг Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгуулагаас тогтооно.